



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОО-2020/42/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас:70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: С.Энхбаатар Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatars@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.14 № 64

танай _____-ны № _____-т

ХЭРЛЭН СУМЫН 5 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Т.ТОДГЭРЭЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110519522

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Т.Тодгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс 2020 оны 02 дугаар сарын 07-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор С.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын

суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх"-д оршино.

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тус цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага мөн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн 5 дугаар цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд 8 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 287,663.4 мянган төгрөгөөс тооцон 5,753.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,583.4 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 96,104.3 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар

өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	38,436.1	36,554.6	-1,881.5
Үндсэн хөрөнгө	1,154,243.5	1,276,517.8	122,274.3
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-39,525.2	-63,813.8	-24,288.6
Нийт хөрөнгө	1,153,154.3	1,249,258.6	96,104.3
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,153,154.3	1,249,258.6	96,104.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,153,154.3	1,249,258.6	96,104.3

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 1,839.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 530,3 мянган төгрөгийн бусад хангамжийн материал акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь барилга байгууламж 102079.6 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмж 520.0 мянган төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө 19286.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь үнэ төлбөргүйгээр аймгийн ОНХС-аас 102079.6 мянган төгрөг, БСШУЯ-аас 520.0 мянган төгрөг, Хэрлэн сумын ОНХС-аас 19,286.3 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,249,258.6 мянган төгрөг болж 96,104.3 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь үнэ төлбөргүйгээр үндсэн хөрөнгө шилжүүлэн авсантай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус цэцэрлэгийн хувьд орлогын төлөвлөгөө байхгүй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 305,311.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 305,311.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 281,511.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 23,800.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөгджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 301,805.6 мянган төгрөг буюу 98,8 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төсвийн хуваарийн дагуу зардлыг зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Цахим тендерийн баримт бичгийн орлогоор 445.5 мянган төгрөгийг бүрдүүлснээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 236.5 мянган төгрөг, тендерийн бичиг хэргийн хэргийн зардалд 209.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 33,229.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 30,860.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2,369.5 мянган төгрөгийн алдаанд залруулга хийлгэж, 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар дараах 30,860.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд хийсэн 28227.3 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 345 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
2. Хоолны зардлаас 2,632.8 мянган төгрөгийг цалинд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.-д “батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-

ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Санхүүгийн программын ашиглалтын талаар:

1.1. Илрүүлэлт: Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны үзүүлэлтүүдийг дутуу илэрхийлсэн байна.

1.2. Эрсдэл: Тайлан буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,436,054.66	36,554,565.66
35	БАРАА МАТЕРИАЛ	38,436,054.66	36,554,565.66
354	Хангамжийн материал	38,436,054.66	36,554,565.66
35410	Бичиг хэргийн материал	735,450.00	881,450.00
35420	Аж ахуйн материал	28,368,568.66	26,529,368.66
35470	Бусад хангамжийн материал	9,332,036.00	9,143,747.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,114,718,280.61	1,212,704,037.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,114,718,280.61	1,212,704,037.94
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	934,438,280.61	1,032,035,537.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	915,269,362.25	1,017,348,962.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-17,233,949.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,881,887.50	13,401,887.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,350,781.53	-10,176,646.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,350,750.00	40,350,750.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,199,645.86	-34,230,239.36
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,691,500.00	23,977,757.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,204,791.75	-1,402,983.42
393	Биет бус хөрөнгө	180,280,000.00	180,668,500.00
39301	Програм хангамж	770,000.00	1,158,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	180,280,000.00	180,280,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,153,154,335.27	1,249,258,603.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,153,154,335.27	1,249,258,603.60
51	Засгийн газрын хувь оролцоо	1,153,154,335.27	1,249,258,603.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	184,855,297.56	184,855,297.56
51101	Өмч: - төрийн	184,855,297.56	184,855,297.56
512	Хуримтлагдсан үр дүн	142,664,262.79	238,768,531.12
51210	Өмнөх үеийн үр дүн	142,664,262.79	142,664,262.79
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	96,104,268.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	825,634,774.92	825,634,774.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,153,154,335.27	1,249,258,603.60

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	278,911,791.00	427,642,657.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,800,000.00	121,885,857.00
121	Хөрөнгийн орлого	1,800,000.00	121,885,857.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	1,800,000.00	121,885,857.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	570,891.00	24,245,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	276,540,900.00	281,511,300.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	570,891.00	445,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	570,891.00	445,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	23,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	23,800,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	287,663,444.65	331,538,388.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,663,444.65	331,538,388.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	280,376,477.65	327,832,701.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,623,392.74	206,935,791.00
210101	Үндсэн цалин	151,724,674.74	184,659,479.00
210102	Нэмэгдэл	7,117,768.00	6,794,589.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	14,780,950.00	15,481,723.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,315,333.00	25,815,108.84
210201	Тэтгэврийн даатгал	13,380,833.00	17,536,808.84
210202	Тэтгэмжийн даатгал	1,687,600.00	2,069,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,432,900.00	1,655,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	346,700.00	413,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,467,300.00	4,139,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,674,065.00	19,069,613.00
210301	Гэрэл, цахилгаан	3,481,951.00	2,912,803.00
210302	Түлш, халаалт	10,672,212.00	10,814,356.00
210303	Цэвэр, бохир ус	4,519,902.00	5,342,454.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,410,200.00	3,741,939.00
210401	Бичиг хэрэг	150,200.00	312,450.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,000.00	160,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	500,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал ахталсны зардал	00.00	2,369,489.00
2105	Нормативт зардал	52,867,700.00	45,728,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	30,000.00
210502	Хоол, хүнс	52,367,700.00	45,198,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	900,000.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	900,000.00	1,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	147,200.00	147,200.00
210702	Дотоод албан томилолт	147,200.00	147,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	246,000.00	230,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,000.00	50,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,192,586.91	24,864,599.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	256,800.00	176,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,635,786.91	24,288,599.67

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,286,967.00	3,705,687.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,181,800.00	200,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,081,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	105,167.00	3,505,687.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,167.00	3,505,687.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,751,653.65	96,104,268.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,751,653.65	96,104,268.33

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	277,111,791.00	305,756,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	277,111,791.00	305,756,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	276,540,900.00	281,511,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	570,891.00	445,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	570,891.00	445,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	23,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	23,800,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	277,111,791.00	305,756,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	277,111,791.00	305,756,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,824,824.00	302,051,112.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,846,159.00	206,953,700.00
210101	Үндсэн цалин	151,947,441.00	184,677,387.00
210102	Нэмэгдэл	7,117,768.00	6,794,589.00
210104	Урамшуулал	14,780,950.00	15,481,724.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,803,700.00	25,797,199.84
210201	Тэтгэврийн даатгал	13,869,200.00	17,518,899.84
210202	Тэтгэмжийн даатгал	1,687,600.00	2,069,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,432,900.00	1,655,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	346,700.00	413,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,467,300.00	4,139,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,674,065.00	19,069,613.00
210301	Гэрэл, цахилгаан	3,481,951.00	2,912,803.00
210302	Түлш, халаалт	10,672,212.00	10,814,356.00
210303	Цэвэр, бохир ус	4,519,902.00	5,342,454.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,710,000.00	1,768,450.00
210401	Бичиг хэрэг	250,000.00	458,450.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,000.00	160,000.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	100,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	52,897,700.00	45,728,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,000.00	30,000.00
210502	Хоол, хүнс	52,367,700.00	45,198,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	900,000.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	900,000.00	1,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	147,200.00	147,200.00
210702	Дотоод албан томилолт	147,200.00	147,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	246,000.00	486,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,000.00	306,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,286,967.00	3,705,687.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,181,800.00	200,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,081,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	105,167.00	3,505,687.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,167.00	3,505,687.16
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,855,297.56	825,634,774.92	142,664,262.79	00.00	1,153,154,335.27
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,855,297.56	825,634,774.92	142,664,262.79	00.00	1,153,154,335.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	184,855,297.56	825,634,774.92	142,664,262.79	00.00	1,153,154,335.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	96,104,268.33	00.00	96,104,268.33
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,855,297.56	825,634,774.92	238,768,531.12	00.00	1,249,258,603.60

5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	305,311,300.00	301,805,612.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	305,311,300.00	301,805,612.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	305,111,300.00	301,605,612.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,953,700.00	206,953,700.00
210101	Үндсэн цалин	185,236,100.00	184,677,387.00
210102	Нэмэгдэл	7,111,600.00	6,794,589.00
210104	Урамшуулал	14,606,000.00	15,481,724.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,868,900.00	25,797,199.84
210201	Тэтгэврийн даатгал	17,590,900.00	17,518,899.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,069,600.00	2,069,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,543,600.00	1,655,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	525,700.00	413,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,139,100.00	4,139,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,500,000.00	19,069,613.00
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	2,912,803.00
210302	Түлш, халаалт	12,500,000.00	10,814,356.00
210303	Цэвэр, бохир ус	5,500,000.00	5,342,454.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,560,000.00	1,559,450.00
210401	Бичиг хэрэг	250,000.00	249,450.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,000.00	160,000.00
210404	Ном, хэвлэл	250,000.00	250,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	45,728,700.00	45,728,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,000.00	30,000.00
210502	Хоол, хүнс	45,198,700.00	45,198,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	150,000.00	147,200.00
210702	Дотоод албан томилолт	150,000.00	147,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	250,000.00	250,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,000.00	70,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800000.00	800000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200000.00	200000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	305,311,300.00	305,311,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	281,511,300.00	281,511,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	281,511,300.00	281,511,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,800,000.00	23,800,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	23,800,000.00	23,800,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00